

Товъёог

Д/д	Товч утга	Хуудасны тоо	Хуудасны дугаар
1	Засгийн газрын тогтоол	1	
2	Сайдын тушаал	2	
3	Сайдын албан даалгавар	1	
4	НДЕГ-ын даргын тушаал	23	
5	НДЕГ-ын албан даалгавар	1	

**ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025-06-30

№	Шийдвэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)
Нэг. Засгийн газрын тогтоол					
1	02	2025.01.02	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь хэмжээг тогтоох тухай	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувиар тогтоосныг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн сумдын байцаагчид хүргүүлэн ажиллаж байна.	100%
Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн дундаж:100%					
Хоёр. Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Сайдын тушаал					
1	A/101	2024.05.08	Төлөвлөгөө батлах тухай	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн A/101 дугаар тушаалын 49,50,51 дэх заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
2	A/57	2025.02.25	Мэргэшлийн зэрэг олгох тухай	Тус тушаалын дагуу 15 албан хаагчид мэргэшлийн зэрэг олгон албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэлээ авч байна.	100%
Хөдөлмөр нийгмийн хамгааллын Сайдын тушаалын хэрэгжилтийн дундаж:100%					
Гурав.Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Сайдын албан даалгавар					
1	03	2025.02.25	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай	“Шилэн дансны тухай хууль” болон Засгийн газрын 2026 оны 29-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасан хугацаанд тухай бүр нь мэдээллийг оруулж хэвшсэн.	100%
Сайдын тушаалын хэрэгжилтийн дундаж:100%					
Дөрөв. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
1	A/02	2025.01.06	Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай	2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай" A/02 дугаар тушаалаар 2322079.1 мянган төгрөгний төсөв батлагдсан. Төсвийг зориулалтын дагуу зарцуулан	100%

				ажиллаж байна.	
2	A/08	2025.01.15	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, шилжүүлэх тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчилэн тогтоох, шилжүүлэх тухай” А/08 тушаалын дагуу 13 ширхэг 5,283,900 төгрөгийн тавилга эд хогшлийн үнийг 1,585,170 төгрөгөөр, 31 ширхэг 11,347,316 төгрөгийн машин, тоног төхөөрөмжийн үнийг 5,673,658 төгрөгөөр шинэчилэн санхүүгийн green finance, төрийн өмчийн тооллогын цахим системд бүрэн оруулж бүртгэсэн.	100%
3	A/10	2025.01.20	Төлөвлөгөө батлах тухай	2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө сумын байцаагч нарт хуваарилан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
4	A/15	2025.02.10	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн сарын хуваарийг өөрчлөн батлах тухай	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 54762418.7 мянган төгрөг, зардалын төлөвлөгөө 138047921.1 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.	100%
5	A/24	2025.02.10	Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар тус газрын Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн нарын бичгийн даргаар Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн Д.Лувсандондов нь томилогдохыг зөвшөөрч Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна.	100%
6	A/38	2025.02.19	2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарлах тухай	Тус тушаалын хүрээнд дэд төлөвлөгөөг 15 үзүүлэлт бүхий төлөвлөгөө гарган баталуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
7	A/37	2025.02.18	Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар “Шилдэг зөвлөл шалгаруулах” тухай албан бичгийн хүрээнд удирдамж гарган ажиллаж байна.	100%
8	A/47	2025.02.28	Даатгуулагчийн дэмжих, нийгмийн даатгалын	Тус тушаалын хүрээнд дэд төлөвлөгөөг баталуулж тайлант хугацаанд 4 удаагийн шууд дамжуулалт, 27 удаагийн постер мэдээлэл, 1	100%

			шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг батлах тухай	удаагийн видео контентыг хийн нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан. Тус газрын фейсбүүк пэйж сошиал хуудас нь 4,033 дагагчтай бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дагагч 1,000 мянган дагагчаар нэмэгдсэн байна. Мөн инстаграм хуудас нээн хөтөлж байна. Zavhan.ndaatgal.mn веб хуудас болон Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар хуудсанд нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар нийт 105 мэдээлэл байршуулан түгээж 27,509 иргэнд хүрсэн. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч талуудад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээллийг тогтмол ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор гарын авлага, сурталчилгааны хуудсыг олон нийтийн сүлжээнд байршуулан ажиллаж байна. Мөн ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 94 удаагийн сургалтад 150 аж ахуйн нэгжийн 5448 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулсан. Үр дүнд оны эхний Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 816200.9 мянган төгрөгийн үлдэгдэлээс 624871.5 мянган төгрөгийг барагдуулж, хуримтлагдсан өр авлагын барагдуулалт 76.5 хувьтай байна.	
9	A/50	2025.03.11	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн сарын хуваарыг өөрчлөн батлах тухай	Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын төсвийн сарын хуваарийг урагш татсантай холбоотойгоор НДЕГ-ын “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн сарын хуваарийг өөрчлөн батлах тухай” А/50 тушаалаар төсөв батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.	100%
10	A/51	2025.03.11	Газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 03/667 дугаар албан бичгээр ирсэн Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны “Газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/51 дугаар тушаалыг газрын албан хаагчдад танилцах хуудсаар, сумдын байцаагч, мэргэжилтнүүдэд албаны мэйл хаягаар хүргүүлж нийт 47 албан хаагчид танилцуулж ажилласан.	100%
11	A/68	2025.03.21	Хяналт шинжилгээний ажил зохион байгуулах	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2025 оны “хяналт шинжилгээний ажил зохион байгуулах тухай” А/68 дугаар тушаалаар газрын даргын	100%

			тухай	2024 онд гаргасан захиргааны актын хууль зүйн үндэслэлийг шалгасан бөгөөд үүнэтэй холбоотой газрын даргын 2024 оны А тушаал-53, Б тушаал-79 нийт 132 тушаалыг PDF болгон хүргүүлж, тушаалыг үндсэлж гаргасан АТГ-ын албан тоот, Аймгийн засаг даргын тушаал, ТАЗ-ийн тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох 22 баримтыг хүргүүлэн ажилласан.	
12	A/70	2025.03.25	Журам шинэчлэн батлах тухай	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/70 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын зөвлөлийн ажиллах журам батлагдсан бөгөөд журмыг газрын албан хаагчдад танилцах хуудсаар, сумдын байцаагч, мэргэжилтнүүдэд албаны мэйл хаягаар хүргүүлж нийт 47 албан хаагчид танилцуулж ажилласан.	100%
13	A/71	2025.03.25	Ажлын өдөрт зохицуулалт хийх тухай	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын өдөрт зохицуулалт хийх тухай” А/71 дугаар тушаалын дагуу Монголын уламжлалт цагаан сарын баяраар мягмар гарагт амарсан ажлын өдрийг 2025 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн Бямба гарагт шилжүүлэн нийт ажилтнууд хэвийн цагийн горимын дагуу ажилласан.	100%
14	A/73	2025.03.27	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнээр хуралдаж аймгийн даатгуулагч, хүний Хөдөлмөрийн чавдар алдалтын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг богиносгох шийдвэрлэж байна.	100%
15	A/74	2025.03.23	Сургалт зохион байгуулах, төсвийн хуваарь батлах тухай	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллагуудад урилга хүргүүлэн ажиллаж байна.	100%
16	A/75	2025.03.29	Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай	Нийгмийн даатгалын газрын 2024 оны жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийлгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй байна.	100%
17	A/98	2025.04.23	Сургалт зохион байгуулах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран зохион байгуулсан “Нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудыг чадавхижуулах сургалт”-нд 2 ажилтан хамрагдсан. Сургалтын	100%

				талаархи мэдээллийг ажилтнуудад хүргэн ажилласан.	
18	A/103	2025.04.24	Ажлын хэсэг байгуулах тухай	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/103 дугаар тушаалаар нийгмийн даатгалын өр авлагыг барагдуулах, шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран ажиллах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлын хэсэгт томилогдон ажиллаж байна. 2 байгууллагын 4,085,100 төгрөгийн төлбөр гаргуулах гүйцэтгэх хуудсыг, Завхан аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт, 1 байгууллагын 14,682,000 төгрөгийн төлбөр гаргуулах гүйцэтгэх хуудсыг Орхон аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт, 3 байгууллагын 2,249,640 төгрөгийн төлбөр гаргуулах гүйцэтгэх хуудсыг Тосонцэнгэл сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст хүргүүлсэн. Үүнээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар 3 байгууллагын 2,809,940 төгрөгийн шимтгэлийн өр төлөгдсөн байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа гүйцэтгэх баримт бичгийн мэдээллийг сар бүр солилцож, тооцоо нийлэн ажиллаж байна.	100%
19	A/104	2025.04.24	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт шалгалтын удирдамж батлах тухай	Нийгмийн даатгалын газрын сумдын байцаагчдад болон Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт албан бичиг хүргүүлэн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад оронд амьдарч байгаа иргэдийн судалгаагаар аймгийн хэмжээнд 2 тэтгэвэр авагч байна. “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт шалгалтын удирдамж батлах тухай” албан бичиг ирснийг тухайн тэтгэвэр авагчдад мэдэгдэн дахин магадлалд хамрагдахад шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг тэтгэвэр авагчид мэдэгдсэн. Одоогийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад оронд амьдарч байгаа 1 иргэн дахин магадлалд хамрагдахаар материалаа бүрдүүлэн ирүүлсэн байна.	100%
20	A/130	2025.05.06	Ажлын хэсэг байгуулах тухай	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем нэвтрүүлсэнтэй холбоотой ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 1 ажилтан орсон. Ажлын хэсгийн 1 удаагийн уулзалтанд хамрагдсан. Програм хангамжид хийж	100%

				хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нийт байцаагч ажилтнуудад танилцуулсан.	
21	A/129	2025.05.06	Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 онгы төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай	Сангийн яамнаас үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны 05-11 дүгээр саруудын төсвийг 2025 оны 12 дугаар сарын төсөв рүү шилжүүлсэнтэй холбоотойгоор НДЕГ-ын “Үйл ажиллагааны урсгал зардалын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөн батлах тухай” А/129 тушаалаар төсөв батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.	100%
22	A/140	2025.05.19	Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны “Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” А/140 дугаар тушаалаар тус газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, шинэ бүрэлдэхүүнээр маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаагаа явуулж байна.	100%
23	A/143	2025.05.20	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн сар, улиралын хуваарыг өөрчлөн батлах тухай	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө -54762418.7 мянган төгрөг, зардалын төлөвлөгөө - 137058421.1 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.	100%
НДЕГ-ын даргын тушаалын дундаж: 100 %					
Тав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар					
1	01	2025.03.14	Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай	Тус албан даалгаврын хүрээнд 23 заалт, 40 арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган батлуулан төлөвлөгөөний хэрэгжилийг ханган ажиллаж байгаа бөгөөд хийж гүйцэтгэсэн ажлаасаа дурьдвал: - Ажлын байран дахь стресс бууруулах, албан хаагчдийн мэдлэгийг дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн 19 удаагийн танхимын болон цахим сургалт зохион байгуулагдаж давхардсан тоогоор 245 албан хаагч хамрагдсан. Үүнээс ажлын байрны стресс бууруулах, албан хаагчийн сэтгэлзүйн сургалтыг Аймгийн боловсролын газрын “Насан туршийн боловсролын төв”-тэй хамтран 1 удаа зохион байгуулсан. - Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар нь байгууллагын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-тоо бөгөөд тус хороо нийт	100%

				ажилтнуудыг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг тогтмол зохион байгуулж ажилладаг. 2025 оны эхний байдлаар 5 удаагийн сургалт зохион байгуулсан. • Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 25310909.6 мянган төгрөгөөр буюу 100.2 хувиар биелүүлсэн. • Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог цөөрүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ажлын хэсгийг томилон Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг нийт хүн амд харьцуулсан судалгааг гаргахад 3.8 хувь байна. 38.8 хувь нь Нийгмийн халамжийн сангаас 61.2 хувь нь Нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 2715 байсан бол 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2695 болж өмнөх оноос 0.7 хувиар буурсан байна. Өнгөрсөн 5 жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ тогтоолгосон иргэдийн хувь тогтмол буурсан үзүүлэлттэй байгаа боловч улсын дундаж (2.9%)-аас өндөр байгаа 3.8% байна. Үүний шалтгаануудыг ажлын хэсэг судалж үзэхэд Сэтгэц болон зан үйлийн эмгэг, Гэмтэл согогийн өвчин тогтмол өндөр байгаа шалтгаан оюуны хомсдол өндөр байна. Оюуны хоцрогдлыг оюуны хомсдолоос ялгахгүй IQ тогтоосон байгаа нь Сэтгэцийн өвчин нэгдүгээр байх шалтгаан гэж үзэж байна. Мөн Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд осол гэмтэлд өртсөн иргэдэд тавих хяналт муу, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ нь хөгжөөгүй байдаг зэргээс шалтгаалан Гэмтэл согогийн өвчнөөр өвчлөн хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй хамгийн том шалтгаан болж байна. Цаашид мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн баг томилуулан дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.	
НДЕГ-ын даргын албан даалгаварын дундаж: 100%					

ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР